

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

“АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН”-Д
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:
АРА-2021/01/-СТА-ТЕЗ



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2021 ОН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр

Утас: 7033-3141 Цахим хаяг: ulambayard@audit.gov.mn

Аудитын менежер Т.Байгалмаа

Утас: 7033-2860 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn

Аудитор Ж.Мөнгөншагай

Утас: 9090-9190 Цахим хаяг: mungunshagaij@audit.gov.mn

Аудитор П.Энхжаргал

Утас: 9974-3112 Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



Тайланг бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Д.Уламбаяр Аудитын менежер Т.Байгалмаа Аудитор Ж.Мөнгөншагай П.Энхжаргал 2021 оны 04 дүгээр сар Уг тайланг Аимгийн Аудитын газрын Вэб сайт-аас үзнэ үү. www.audit.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах асууж лавлах зүйл байвал 70332860, 70333019 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу, Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот	Агуулга Товчилсон үгсийн тайлбар.....3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4 БҮЛЭГ 1: ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮНДЭСЛЭЛД ӨМНӨХ ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭЭГҮЙ БАЙНА. БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ 164.4 ХУВИАР БУЮУ 5,471.9 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВСАН Ч ЗАРИМ НЭР ТӨРЛӨӨР ТАСАРСАН БАЙНА. БҮЛЭГ 3: ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ 93.4 ХУВЬТАЙ БАЙНА. БҮЛЭГ 4: ТЕЗ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ САЙДУУДААС ИРҮҮЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖААР 90.1 ХУВЬТАЙ БАЙНА. БҮЛЭГ 5: НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА. БҮЛЭГ 6: НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН ТАЛААР ЗӨВЛӨМЖ
--	--



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга хот байгууллагын сайд
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
НХС	Нийгмийн халамжийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Нэг. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ

Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 тоот тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 д заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

АУДИТЫН ЗОРИЛТ

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар ҮАГ, аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- 2020 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн эсэх
- 2020 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- 2020 оны төсвийн зарлагын гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлт
- ТЕЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.
- Нэмэлт санхүүжилтийн талаар

АУДИТЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитыг аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сан, ТЕЗ-ийн сайдуудтай байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, засаг даргын хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардал зэрэг дансдын судалгаа мэдээлэл болон баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, аудитын олон улсын стандарт, МУЕА ын А/106-р тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан Төрийн аудитын газрын 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэн, Санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох ажмлтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ж.Мөнгөншагай, П.Энхжаргал нар төлөвлөгөө,



хөтөлбөрийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 2020 оны 04 дүгээр сарын 23-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн 2020 оны төсөвт 2 удаа тодотгол хийгдсэн бөгөөд Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 сарын 03 –ны өдрийн *“Аймгийн төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай”* 04 дүгээр тогтоолоор аймгийн төсвийн орлого, зарлагын тэнцлийг **79,145.4** сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2020 оны төсвийн суурь орлогыг Сангийн яамнаас **8,064.5** сая төгрөгөөр хянаж ирүүлснийг сум, орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан хуулиар эрх олгогдсон зарим нэр төрлийн орлогыг **430.4** сая төгрөгөөр нэмэгдүүлэн Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03–ны өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн орлогыг **8,301.7** сая төгрөгөөр баталсан бөгөөд Өндөр-Улаан сум 2.7 сая төгрөгөөр, Хайрхан сум 10.9 сая төгрөгөөр, Өлзийт сум 22.5 сая төгрөгөөр, Хотонт сум 38.1 сая төгрөгөөр, Эрдэнэбулган сум 114.0 сая төгрөгөөр, Цахир сум 5.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсвийн нийт орлогын төлөвлөгөөг **8,494.9** сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансаар 2020 онд нийт **4,298.7** сая төгрөг зарцуулагдсан байна.



БҮЛЭГ 1: ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Орон нутгийн орлогын төлөвлөлтийн үндэслэлд өмнөх оны гүйцэтгэлийг харгалзан үзээгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулийг баталжээ.

Хуулийн 15 дугаар зүйлд 2020 оны төсвийн жилд Архангай аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 13,051.5 сая төгрөгөөр, 17 дугаар зүйлд ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4,778.4 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 50,523.6 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Өмнөх онтой харьцуулахад улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 2,298.6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 10,308.5 сая төгрөгөөр өсч, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 691.5 сая төгрөгөөр буурсан байна.

Архангай аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн 08 дугаар тогтоолоор 2020 оны орон нутгийн төсвийн эх үүсвэрийг 80,580.6 сая төгрөгөөр баталсныг 2020 оны 12 дүгээр сарын 03-ны өдрийн 04 дугаар тогтоолоор 79,145.3 сая төгрөг болгон 1,435.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ нь Ковид-19 буюу цар тахлын улмаас эдийн засгийн хүндрэл үүссэнээс шалтгаалан 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг бууруулж баталсантай холбоотойгоор улсын төсвөөс олгох санхүүжилтийг 1,480.6 сая төгрөгөөр бууруулан, орон нутгийн орлогын төлөвлөгөөг 45.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

2020 оын төсвийн төсөл боловсруулах удирдамжинд заасан зарчмын хүрээнд 2020 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 23 нэр төрлөөр нийт **7,172.8** сая төгрөгөөр боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3¹-д заасны дагуу Сангийн Яаманд хүргүүлснийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал 27.1 хувиар бууруулж төлөвлөсөн байна.

Орон нутгаас хүргүүлсэн **орлогын төсвийн төслийг** өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэл, Сангийн яамны хянасан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Орлогын нэр төрөл	2019 он		Хүснэгт1 /сая.төг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	СЯ-нд хүргүүлсэн дүн	СЯ-ны хянасан дүн	СЯ ны нэмсэн дүн	Хувь
НИЙТ ОРЛОГО	8,128.0	9,842.1	7,172.8	8,064.5	-891.7	12.4
1.ТАТВАРЫН ОРЛОГО	7,480.5	8,519.4	6,598.1	7,214.0	-615.9	9.3
2.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	632.5	1,272.8	561.2	835.5	-274.3	48.9
3.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	15.0	49.9	13.5	15.0	-1.5	11.1

¹ “Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”



Хүснэгтээс харахад орон нутгаас хүргүүлсэн 2020 оны суурь орлогын төсвийн төлөвлөгөө нь:

1. 2019 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 955.2 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар,
2. Мөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2,669.3 сая төгрөгөөр буюу 27.1 хувиар буурч төлөвлөгдсөн байна.

Төсвийн төсөлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож батлуулан төсвийн төлөвлөлтийг баримтлах талаар аудитаас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Орон нутгийн байгууллагуудын зарлагыг өмнөх оны төлөвлөлтөөс өндөр төлөвлөсөн байна.

Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн ТЕЗ нарын 2020 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар, удирдамжинд Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа Засгийн газраас баталсан төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахыг чухалчилна гэж тусгасан байна.

Энэхүү бодлого, зарчмын хүрээнд 2020 оны орон нутгийн төсвийн суурь зарлагыг нийт **16,172.4** сая төгрөгөөр төслийг боловсруулж Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлсэн ба Сангийн яам **3,234.0** сая төгрөгөөр буюу **19.9** хувиар бууруулж **12,938.4** сая төгрөгөөр хянажээ.

Орон нутгаас хүргүүлсэн зарлагын төслийг өмнөх онуудын төсөв, Сангийн яамны хянаж батлагдсан дүнтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 3 /сая. төг/

№	Байгууллагын нэр, зардлын дансны нэр	2019 он	2020 он		
		Төлөв	Төсөл	СЯам хянасан	Аймаг баталсан анх
	орон нутгийн суурь зарлагын дүн	12,655.9	16,172.4	12,938.5	20,330.8

Хүснэгтээс харахад:

2020 оны орон нутгийн төсвийн зарлагыг нийт дүнгээр **16,172.4** сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2018 оны төлөвлөгөөнөөс **6,512.0** сая төгрөгөөр бууруулсан бол 2019 оны төлөвлөгөөнөөс **3,516.5** сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн төслийг өмнөх оноос нэмэгдүүлсэн нь 2020 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжинд тусгасны дагуу төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой байна.

Архангай аймгийн ИТХурлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 08 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зарлагыг 15147.7 сая төгрөг, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг болон бусад орлогыг 65432.8 сая төгрөгөөр буюу нийт зардлыг 80,580.5 сая төгрөгөөр баталсан байна.



БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Орон нутгийн төсвийн орлого 5,471.9 сая төгрөгөөр давсан ч зарим нэр төрлөөр тасарсан байна.


Аймгийн 2020 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 04 тоот тогтоолоор төсвийн орлогыг нийт **8,494.9** сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр **13,966.7** сая төгрөг төвлөрч төлөвлөгөө 164.4 хувиар буюу **5,471.8** сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	7,423.6	12,487.6	5,064.0	168.2
Татварын бус орлого	1,056.3	1,415.4	359.1	134.0
Хөрөнгийн орлого	15.0	63.7	48.7	424.7
нийт дүн	8,494.9	13,966.7	5,471.8	164.4

Орон нутгийн төсвийн орлогын 89.4 хувь нь татварын орлогоос, 10.1 хувь нь татварын бус орлогоос, 0.5 хувь нь хөрөнгийн орлогоос тус тус бүрдсэн байна.

2020 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

График 1/ сая.төг/



Тухайн графикаас харахад 2020 оны төсвийн орлогын төлөвлөлт 2018 оноос 1768.9 сая төгрөг, 2019 онуудаас 366.9 сая төгрөгөөр, харин орлогын гүйцэтгэл 2018 оноос 5498.9 сая төгрөгөөр, 2019 онуудад 4,124.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

2020 онд Төсвийн 17 нэр төрлийн орлого нийт дүнгээрээ 5,580.6 сая төгрөгөөр давж биелсний 44 хувь буюу 2458.1 сая төгрөг нь байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогоос сумдад орсон орлого эзэлж байна.

Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Цэнхэр	0.2	683.4	683.2
Булган	0.08	348	347.9
Ихтамир	0.09	722.1	722.0
Жаргалант	0.2	703.6	703.4
нийт дүн	0.57	2,457.1	2,456.5



2020 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал:
Хүснэгт 6 /сая.төг/

2020 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ДАВСАН ОРЛОГУУД					
№	Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	4,500.0	5,597.5	1,097.5	124.4
2	Аж ахуй эрхэлсний орлогын албан татвар	109.2	143.7	34.5	131.6
3	Шууд бус орлого	440.0	975.2	535.2	221.6
4	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	60.0	151.4	91.4	252.3
5	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	(800.0)	(559.3)	240.7	69.9
6	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүнээс/	1,277.5	1,520.0	242.5	119.0
7	Бууны албан татвар	80.0	80.3	0.3	100.4
8	Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	345.0	398.0	53.0	115.4
9	Газрын дуудлага худалдааны орлого	215.7	550.7	335.0	255.3
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	33.4	58.2	24.8	174.3
11	Байгалийн ургамал ашигласны төлбөр	1.0	2,459.2	2,458.2	245,920.0
12	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	52.0	58.9	6.9	113.3
13	Ойн нөөц ашигласны төлбөр	288.1	300.9	12.8	104.4
14	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	5.0	8.7	3.7	174.0
15	Төсөвт байгууллагын өөрийн орлого	97.8	170.4	72.6	174.2
16	Хүү торгуулийн орлого	586.5	909.3	322.8	155.0
17	Хөрөнгө борлуулсны орлого	15.0	63.7	48.7	424.7
ДҮН		7,306.2	12,886.8	5,580.6	248,629.8
2020 ОНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨНӨӨС ТАСАРСАН ОРЛОГУУД					
№	Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үл хөдлөх хөрөнгийн татвар	265.0	261.2	-3.8	98.6
2	Улсын тэмдэгийн хураамж	250.0	216.5	-33.5	86.6
3	Газрын төлбөр	97.0	62.5	-34.5	64.4
4	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	204.7	203.5	-1.2	99.4
5	Хувьцааны ногдол ашиг	10.0	-	-10.0	-
6	Нэр заагдаагүй бусад орлого	362.0	335.7	-26.3	92.7
ДҮН		1,188.7	1,079.4	-109.3	441.7
НИЙТ ДҮН		8,494.9	13,966.2	5,471.3	249,071.5

Давсан 17 нэр төрлийн орлогоос их хэмжээгээр давж биелэсэн дараах нэр төрлийн орлогыг тодруулбал:

- ✚ Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар 1.2 дахин давж биелэсэн нь Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.
- ✚ Хадгаламжийн хүүгийн орлого 1.2 дахин давж биелэсэн нь арилжааны банкин дахь иргэдийн хадгаламж өссөнтэй холбоотой байна.
- ✚ Шууд бус орлого 2.2 дахин давж биелэсэн нь Эрдэнэс таван толгойн хувьцааны орлогоос 487.9 сая төгрөгийн татвар орсонтой холбоотой байна.
- ✚ Газрын дуудлагын худалдааны орлого 2.6 дахин давж биелэсэн нь Батцэнгэл, Тариат, Өндөр-Улаан, Өлзийт, Эрдэнэмандал зэрэг сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын дуудлага худалдааны орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Дээрх 6 нэр төрлийн орлого тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- ✚ Үл хөдлөх эд хөрөнгийн татварын орлого 3.8 сая төгрөгөөр тасарсан нь Төвшрүүлэх сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй 2 аж ахуйн нэгж нь хөрөнгийн татварын 39.8 сая



төгрөгийн өртэй байсныг барагдуулахаар арилжааны банкин дахь харилцах дансыг хааж, хөрөнгийг битүүмжилсэн хэдий ч 2020 онд үйл ажиллагаа эрхлээгүйгээс төвлөрүүлж ажиллаагүй байна.

- ✚ Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 33.5 сая төгрөгөөр тасарсан нь Иргэдийн лавлагаа цахимжсан, нотриатын үйлчилгээ багассан, тамхи худалдаалах зөвшөөрөл шинээр олгогдоогүй, ХХААХҮЯ-ны 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн а/272 тоот тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, сумдад тогтоосон тул зөвшөөрлийн тоо багассан зэргээс шалтгаалан тасарсан байна.
- ✚ Хог хаягдлын үйлчилгээний хураамж 1.2 сая төгрөгөөр тасарсан нь Засгийн газрын тогтоолоор цар тахлын улмаас 2020 оны 12 дугаар сард чөлөөлсөнтэй холбоотойгоор тасарсан байна.
- ✚ Газрын төлбөрийн орлого 34.5 сая төгрөгөөр тасарсан нь тайлант онд орлогын төлөвлөгөө өндөр батлагдсан, Цэнхэр сумын Орхон багт үйл ажиллагаа явуулж байсан 10 аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсантай холбоотойгоор тасарсан байна.
- ✚ Хувьцааны ногдол ашгийн орлого 10 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн “Ар-Ус Ундарга” ХХК нь 2019-2020 онуудад ашиггүй ажилласнаас шалтгаалсан байна.

Орон нутгийн ТЕЗ-чийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн орлоготой холбоотой илрүүлэлт :

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг орлогын нэр төрөл бүр дээр дүн шинжилгээ хийж, биелэгдэхүйц бодит тоон мэдээ судалгаанд үндэслэн төлөвлөж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлээ.

БҮЛЭГ 3: ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Төсийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл 93.4 хувьтай байна.

3.1 Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн зарлагыг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн “*Аймгийн 2020 оны төсөвт зохицуулалт хийж тодотгон батлах тухай*” 04 дүгээр тогтоолоор **79,145.3** сая төгрөгөөр баталсан байна.

ТЕЗахирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөөний дүн аймгийн ИТХурлаар баталсан дүнгээс **5,796.7** сая төгрөгөөр илүү тайлагнагдсан нь сумын ИТХурал бүрэн эрхийнхээ хүрээнд сум хөгжүүлэх сангийн төлөвлөгөөг **3,115.7** сая төгрөгөөр, ОНХСангийн өмнөх оны үлдэгдлийг **702.6** сая төгрөгөөр, удирдлагын байгууллагын өмнөх оны үлдэгдлийг **1,575.9** сая төгрөгөөр, удирдлагын байгууллагын зардлыг **193.2** сая төгрөгөөр тодотгон нэмэгдүүлсэн, мөн аймгийн Мал хамгаалах сангийн хөрөнгө **88.7** сая төгрөг, Сангийн яамны хянасан суурь зарлагыг **120.6** сая төгрөгөөр тус тус нэмсэнтэй холбоотой байна.



2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр харуулбал:

Хүснэгт 9 /сая.төг/

Үзүүлэлт	2020 оны ИТХ ын тогтоол	2020 оны нэгдсэн тайлан			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79145.3	84,942.0	79,350.2	5,591.8	93.4
А. УРСГАЛ ЗАРДАЛ	72753.7	75,475.9	72,635.2	2,840.7	96.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	70950.2	73,672.4	71,120.1	2,552.3	96.5
Татаас	108.0	108.0	87.8	20.2	81.3
Урсгал шилжүүлэг	1,695.5	1,695.5	1,427.3	268.2	84.2
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6391.6	6,391.6	5,061.2	1,330.4	79.2
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	3,074.5	1,653.8	1,420.7	53.8

2020 онд “Ковид-19” цар тахлаас шалтгаалан бүх шатны боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор Монгол улсын Засгийн газрын 2020 оны 98 болон 114 дүгээр тогтоолуудын дагуу **1,940.2** сая төгрөгийг Боловсрол Шинжлэх ухааны яаманд төвлөрүүлснийг орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлаар тайлагнасан байна. Харин Сангийн яамны Төрийн сангийн газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12-1/1473 тоот албан бичгийг үндэслэн төсвийн гүйцэтгэл **80,259.8** сая төгрөгийг **909.7** сая төгрөгөөр бууруулан төвлөрүүлэх шилжүүлгээр тусган **79,350.1** сая төгрөг тайлагнасан байна.

2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг аймаг, сумаар харуулбал:

Хүснэгт 10 /сая.төг/

№	Нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Үүнээс:			
					Эргэж төлөгдөх зээл	Хөрөнгийн зардал		Урсгал зардал
						ОНТ Хөрөнгө	ОНХС	
1	Сумын дүн	69,695.7	65,619.5	4,076.2	1,420.8	238.4	603.2	1,813.7
2	Аймгийн дүн	15,246.3	13,730.6	1,515.7		50.6	438.3	1,026.8
	Нийт дүн	84,942.0	79,350.1	5,591.8	1,420.8	289.0	1,041.5	2,840.5


Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар **5,591.8** сая төгрөгийн хэмнэлт тайлагнагдсан нь дараах зардлуудын гүйцэтгэлтэй холбоотой байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын урсгал зардлын хэмнэлтээс төвлөрүүлсэн нийт **2,840.5** сая төгрөг
- Орон нутгийн төсвийн байгууллагын хөрөнгийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл **289.0** сая төгрөг
- ОНХСангийн хөрөнгийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл **1041.5** сая төгрөг
- СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс зээл олголт **1,420.8** сая төгрөгөөр дутуу олгогдсон.



Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал: /график 2/

Нэр төрөл	2018	2019	2020
Урсгал зардал	60,822.8	61,095.0	72,635.5
Хөрөнгийн зардал	6,237.2	5,245.3	5,061.2
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,838.8	1,593.9	1,653.7



2020 оны гүйцэтгэлийг өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал задал 2018 оноос 11812.7 сая төгрөгөөр, 2019 оноос 11540.5 сая төгрөгөөр өссөн бол, хөрөнгийн зардлын 2018, 2019 онуудаас 184.1- 1176.0 сая төгрөгөөр буурсан байна.

3.2 Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл:

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд **2,975.6** сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн санд **2,572.2** сая төгрөгийг зарцуулахаар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталсан. Гүйцэтгэлээр аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас **2,536.8** сая төгрөг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаас **1,948.9** сая төгрөгийг зарцуулж гүйцэтгэл 80.9 хувьтай байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

Хүснэгт 11 /сая.төг/

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Сумын дүн	2,572.2	1,948.9	623.4	75.8
2	Аймгийн	2,975.6	2,536.8	438.8	85.3
Нийт дүн		5,547.8	4,485.7	1,062.2	80.9

3.3 Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын гүйцэтгэл:

Тусгай зориулалтын байгууллагын шилжүүлгийн зарлага **58,014.5** сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс **55,607.3** сая төгрөгийн буюу 95.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 12 /сая.төг/

Ерөнхийлөн захирагч	Хөтөлбөр зориулалт	2020 оны батлагдсан төсөв	2020 оны зарцуулалт	Зөрүү
Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	8,214.9	8,096.5	118.4
БХБ сайд	Газрын харилцаа, кадастрийн тусгай зориулалт	596.9	581.1	15.8
БШУС сайд	Сургуулийн өмнөх боловсрол	13,330.4	12,556.2	774.2
БШУС сайд	Ерөнхий боловсрол	33,402.1	32,095.7	1,306.4
БШУС сайд	Насан туршын болон албан бус боловсрол	196.3	186.6	9.7
БШУС сайд	Биеийн тамир спорт	799.1	693.4	105.7
Соёлын сайд	ХДТеатр, Номын сан, Музей	1,068.3	1,008.5	59.8
ХНХ сайд	Хүүхдийн хөгжил хамгаалал	406.5	389.3	17.2
Нийт дүн		58,014.5	55,607.3	2,407.2



Аймгийн тусгай зориулалттай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтын 57.7 хувийг ерөнхий боловсролын сургууль, 22.6 хувийг СӨБ, 14.6 хувийг Эрүүл мэндийн байгууллагууд, 5.1 хувийг бусад тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагууд эзэлж байна.

3.4 Халамжийн сангийн гүйцэтгэл:

2020 онд Халамжийн сангийн зарлагыг аймгийн ИТХурлаар **108.0** сая төгрөгөөр төлөвлөснөөс **100.8** сая төгрөгийн санхүүжилт олгосон гүйцэтгэл 93.3 хувьтай байна.

Төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 13 /сая.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Үлдэгдэл
НХСан	108.0	100.8	7.2
Нийт дүн	108.0	100.8	7.2

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар халамжийн сангийн арилжааны банкин дахь үлдэгдлийг ИТХ-аар батлуулан зарцуулаагүй байгаад аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулж ажиллах зөвлөмжийн биелэлтийг 100 хувь ханган ажилласан байна.

3.5 Мал хамгаалах сангийн гүйцэтгэл:

Аймгийн Мал хамгаалах сангаас **74.1** сая төгрөгийг зарцуулсан байна.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Мал хамгаалах сангийн хөрөнгийг аймгийн ИТХурлаар батлуулан ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн боловч Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-д “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасныг мөрдөөгүй, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

3.6 Авто замын сангийн гүйцэтгэл:

Аймгийн ИТХурлаар авто замын сангийн хөрөнгөөр 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 435.0 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 371.5 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 85.4 хувьтай байна.

3.7 Засаг даргын хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын гүйцэтгэл:

Аймгийн ИТХ-ын тогтоолоор засаг даргын хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд **723.7** сая төгрөг батлаж, **697.1** сая төгрөгийг зарцуулж **26.6** сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.



3.8 Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын илрүүлэлт :

Аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой дараах нийтлэг зөрчил илэрсэнд аудитаас дараах шийдвэрийг хүргүүллээ.

1. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт **92.0** сая төгрөгийн төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрсэн. Аудитаас Төсвийн Ерөнхийлөн захирагчийн зүгээс аймгийн бүх шатны төсөв захирагчдын төсөв санхүүгийн сахилга батыг сайжруулан, хяналтыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.
2. Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар засаг даргын хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан **115.1** сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.
3. Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1 “тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/”, 54.5.4. “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/” гэсэн заалтын дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж, тайлагнаагүйд аудитаас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж хүргүүллээ.
4. Аймгийн ИТХ-ын төсөв тодотгосон тогтоолд аймгийн ОНХСангийн хөрөнгийг 120.6 сая төгрөгөөр дутуу баталсан, зарим төсөвт байгууллагын төсвийн хуваарьт оруулсан өөрчлөлт нь төсөв захирагчдын санал, нотлох баримтанд үндэслээгүйд аудитаас Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 “Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн энэ хуулийн 11 дүгээр зүйл, 65.1, 66.1-д заасан эрх бүхий этгээд баталж, мөрдүүлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллах зөвлөмж хүргүүллээ.

БҮЛЭГ 4: ТЕЗ-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ САЙДУУДААС ИРҮҮЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖААР 90.1 ХУВЬТАЙ БАЙНА.

Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилт:

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн яамдын сайдуудтай байгуулсан гэрээний биелэлтийг **жилийн** эцсийн гүйцэтгэлээр авч үзэхэд **сайдуудаас ирүүлсэн үнэлгээний дундажаар гэрээний хэрэгжилт 90.1** хувьтай дүгнэгджээ.



Хүснэгт 14 /сая.төг/

№	Гэрээ байгуулсан сайд	АХ-ний тоо	Биелэлтийн явц					Биелэлтийн дундаж хувь
			100	70	30	0	Хэрэгжих хугацаа болоогүй	
1	Монгол улсын шадар сайд	29	19	8			2	91.1
2	МУ-ын сайд, ЗГ-ын хэрэг эрхлэх газрын дарга	18	177				1	100
3	Байгаль орчин аялал жуулчлалын сайд	56	35	5	4	1	11	88.2
4	Сангийн сайд	33	29				2	100
5	Хууль зүй, дотоод хэргийн сайд	21	12	4	2		3	85.5
6	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	29	16	11	1		1	85.7
7	Батлан хамгаалах яам /МУ-ын шадар сайд/	33	25	1	1		6	96.2
8	Барилга, хот байгуулалтын сайд	72	41	22	3		6	86.8
9	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайд	89	78	5	2	1	3	95.4
12	Зам, тээврийн хөгжлийн сайд	28	21	6	1			91.9
10	Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайд	23	4	3			16	87.1
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	49	39	8			2	94.8
13	Эрчим хүчний сайд	11	5	3	2		1	77
14	Эрүүл мэндийн сайд	55	45	6	2	1	1	90.9
15	Үндэсний хөгжлийн газрын дарга	17	6	2	1		8	82
НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО		563	394	84	19	3	63	90.1

2020 онд ТЕЗ нийт 563 заалт бүхий арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаас 394 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 103 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 3 арга хэмжээ хангалтгүй, 63 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй байна.

БҮЛЭГ 5: НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ХӨРӨНГИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

5.1 Тайлант онд **4,298.7** сая төгрөгийн нэмэлт төсвийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос **1,606.6** (62.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 15 /сая.төг/

Салбарын ангилал	Авсан нэмэлт санхүүжилт /сая.төг/
Орон нутгийн төсвийн байгууллагууд	3,752.4
Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	214.2
Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайд	16.7
Эрүүл мэндийн сайд	69.7
Барилга хот байгуулалтын сайд	245.7
Нийт дүн	4,298.7

Нийт зардлын 87.3 хувь буюу **3,752.4** сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагууд, 5 хувь буюу **214.2** сая төгрөг нь боловсрол соёлын байгууллага, 0.4 хувь буюу **16.7** сая төгрөг нь Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, 1.6 хувь буюу **69.7** сая төгрөг нь Эрүүл мэндийн салбарын байгууллагууд, 5.7 хувь буюу **245.7** сая төгрөг нь Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зарцуулжээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт **224.4** сая төгрөгийн зөрчил илэрсэнд аудитаас зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахчиглэлээр 1 албан шаардлага, 4 заалт бүхий зөвлөмж өглөө.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр нийт орлого ба тусламж 78428.7 сая төгрөг, нийт зарлага ба зээлийн дүн 79,350.2 сая төгрөг байна.

Бүлэг 1: Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг холбогдох журмын дагуу төлөвлөсөн хэдий ч өмнөх оны төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслээгүй байна.

Бүлэг 2: Төсвийн орлогын гүйцэтгэл 164.4 хувьтай буюу 5,471.9 сая төгрөгөөр давсан ч зарим нэр төрлийн орлого тасарсан байна.

Бүлэг 3: Төсвийн зарлагын гүйцэтгэл 93.4 хувьтай байна.

Бүлэг 4: ТЕЗ-ийн хөтөлбөрийн хэрэгжилт сайдуудаас ирүүлсэн үнэлгээний дундажаар 90.1 хувьтай байна.

Бүлэг 5: Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргад:

- ✚ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/ гэсэн заалтын дагуу төсвийн зарцуулалтад тавих Төрийн сангийн болон төсөв захирагчдын дотоод хяналтыг сайжруулж ажиллах арга хэмжээ авах.
- ✚ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг тайлагнахад анхаарч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.
- ✚ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 “Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн энэ хуулийн 11 дүгээр зүйл, 65.1, 66.1-д заасан эрх бүхий этгээд баталж, мөрдүүлнэ” гэсэн заалтын дагуу төсвийн зохицуулалтыг төсөвт байгууллагын санал хүсэлт, нотлох баримтанд тулгуурлан хийж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.
- ✚ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтын дагуу төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний дотор багтаан Архангай аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.



6.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудит	Аудитын код:
2021			APA-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Аймгийн ТЕЗ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг шалгахад засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан 8 арга хэмжээний нийт 115.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.	115.1	Албан шаардлага хүргүүлэв	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Д.Зожаргал Ж.Мөнхбат
2	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т /өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/ гэсэн заалтын дагуу төсвийн зарцуулалтад тавих Төрийн сангийн болон төсөв захирагчдын дотоод хяналтыг сайжруулж ажиллах арга хэмжээ авах.		Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Д.Зожаргал Ж.Мөнхбат
3	Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг тайлагнахад анхаарч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.		Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Д.Зожаргал Ж.Мөнхбат
4	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 “Төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг үндэслэн энэ хуулийн 11 дүгээр зүйл, 65.1, 66.1-д заасан эрх бүхий этгээд баталж, мөрдүүлнэ” гэсэн заалтын дагуу төсвийн зохицуулалтыг төсөвт байгууллагын санал хүсэлт, нотлох баримтанд тулгуурлан хийж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.		Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Д.Зожаргал Ж.Мөнхбат
5	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтын дагуу төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж ажиллах		Зөвлөмж хүргүүлэв	Засаг дарга, СТСХ-ийн дарга	Д.Зожаргал Ж.Мөнхбат
	Дүн	115.1			



АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/сая.төг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,942,039.3	79,350,238.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	75,475,849.2	72,635,253.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,672,416.0	71,120,102.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,607,857.3	46,329,286.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,286,564.3	6,099,849.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,854,601.8	5,536,219.1
2104	Хангамж, бараа материалын зардал	2,248,054.7	2,163,587.8
2105	Нормативт зардал	5,478,639.9	4,107,406.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	874,035.3	850,612.1
2107	Томилолт, зочны зардал	191,315.6	161,081.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,522,405.7	2,389,180.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,608,941.4	3,482,879.8
212	ТАТААС	107,961.8	87,841.8
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	20,000.0	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	87,961.8	87,841.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,695,471.4	1,427,309.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	140,000.0	140,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,555,471.4	1,287,309.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,391,674.7	5,061,244.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,074,515.4	1,653,740.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,942,039.3	78,428,693.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,523,597.7	48,580,460.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,254,842.8	27,619,782.9
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	642,865.3	572,695.6
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,520,733.5	1,655,754.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,299,847.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,377,090.0



АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/сая.төг/

Код	Үзүүлэлт	Дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,298,706.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,141,831.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,953,200.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,312.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,030.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,936.5
2104	Хангамж, бараа материалын зардал	225,217.6
2105	Нормативт зардал	64,534.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	137,607.8
2107	Томилолт, зочны зардал	33,009.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620,874.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,481,677.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,630.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,186.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	177,443.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156,875.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,295,577.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,295,577.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	3,128.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,128.7

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Т.Байгалмаа

Бэлтгэсэн: Аудитор

Ж.Мөнгөншагай

Аудитор

П.Энхжаргал



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/10

Цэцэрлэг

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2020 оны а/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг тус тус баталгаажуулсугай.

2. Аудитаас өгөгдсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. "Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан"-д хийсэн аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга болон ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Н.Алтантуяад үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.УЛАМБАЯР

003010027



Дарга, тэргүүлэх аудиторын 2021 оны 04 дүгээр сарын

16-ны өдрийн 4/10 тоот тушаалын хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ХҮРГҮҮЛСЭН АЛБАН
ШААРДЛАГА

№	Албан шаардлага хүргүүлсэн байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Мөнгөн дүн /сая төгрөг/	Хариуцсан аудитор
1	Аймгийн ТЕЗ	153/АО340209	115.1	Ж.Мөнгөншагай
2	Аймгийн ТЕЗ	154/АО340209	20.0	Н.Алтантуяа
3	Аймгийн ТЕЗ	155/АО340209	10.9	Н.Алтантуяа
4	Аймгийн ТЕЗ	156/АО340209	-	Н.Алтантуяа



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 153/А0340209

Цэцэрлэг

АРА - 2021/01-СТА-ТЭЗ

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийсэн орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлээ. Аудитаар аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг шалгахад засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй, төсвийг зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан 8 арга хэмжээний нийт 115.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн Аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын ерөнхий аудиторын А/95 тоот тушаалаар баталсан төлбөрийн акт, албан шаардлага өгөх журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх цаашид Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, батлагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах
2. Албан шаардлагын биелэлтийг 2021 оны 12 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн засаг дарга Д.Золжаргал, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Ж.Мөнхбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Уламбаяр





АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС ИРҮҮЛСЭН АСУУДЛЫН БҮРТГЭЛИЙН ХАРИУ ТАЙЛБАР:



**МОНГОЛ УЛС
АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум, 2 дугаар баг,
Утас/Факс: (976) 7033 3208,
И-мэйл: arkhangai.gov@gmail.com,
Вэбсайт: www.arkhangai.gov.mn

2021.04.23 № 01/508
танай 2021.04.22-ны № 206 -т

Тайлбар санал хүргүүлэх тухай

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

А/менеджерт
Саналыг эрхт хэрх! /С,З-г/
- ортайлцуу ирж санал
Боловч хариуцгү эрхч!
Дүн - Н/Г

Танай газрын 2021.04.22-ны өдрийн 206 тоот албан бичгээр ирүүлсэн аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын асуудлын бүртгэлд тусгагдсан зөрчил дутагдал нь өмнөх аймгийн удирдлага, ажлын албатай холбоотой илэрсэн гэж ойлгож байна. Ийм учраас танилцаад танай байгууллагаас ирүүлэх зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авна гэсэн ойлголтоор гарын үсэг зурлаа.

Дараах зарим асуудлыг зөрчил дутагдлаас чөлөөлж өгөхийг хүсч санал, тайлбараа хүргүүлж байна. Үүнд:

Асуудлын бүртгэлийн 7 дахь асуудлыг төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй бүхэлд нь хамруулан ойлгож дүгнэлт хийж болохгүй юм. Энэ нь зөвхөн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, тоо чанарын үзүүлэлтийн тухайлсан асуудал.

Аймгийн төсвийн төслийг 11 сард, боловсруулж, 12-р сарын 05-ны дотор ИТХ-аар батлуулахад хөтөлбөр арга хэмжээний нэрээр төсвийн дүнг хуваарилж болдог, харин ямар ажил хийж, ямар тоо чанарын үзүүлэлт гаргах нь тодорхой болоогүй, салбарын сайд нартай гэрээ, аймаг, сум, байгууллагууд жилийн ажлын төлөвлөгөөгөө батлаагүй байдаг учраас хэрэгжүүлэхэд учир дутагдалтай, барагцаалсан тоо, чанарын үзүүлэлт батлуулахаар тайлагнахад учир дутагдал, бэрхшээлтэй болдог. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийг санхүүгийн нэгтгэсэн тайлан аудитаар баталжсаны дараа Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-д хэлэлцүүлж урьд оны үлдэгдлийг 2021 оны зарлагын эх үүсвэр болгож хуваарилахаар төлөвлөсөн юм. Энэ талаар Санхүү, төрийн сангийн хэлтсээс бичгээр тайлбар өгсөн болно.

Асуудлын бүртгэлийн 8 дахь дотоод хяналттай холбоотой асуудал нь аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст дотоод хяналт, төлбөр тооцооны ахлах мэргэжилтэн гэсэн нэг орон тооны ажилтан ажилладаг. Энэ ажилтан төрийн сангийн гүйлгээний өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажлын чиг үүрэгтэй байдаг. Сангийн сайдын 2015 оны 65 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналтын журмаар сумдын санхүүгийн албаны төрийн сангийн төлбөр тооцооны ажил жилд нэг удаа хяналт шалгалт хийж зөвлөн туслах ёстой байдаг. Гэтэл Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт, төлбөр тооцооны ахлах мэргэжилтэн нь аймгийн төрийн сангийн өдөр тутмын гүйлгээ хянаж баталдаг

651230247

учраас цаг хугацаа, хүний нөөцийн хувьд сумдад тогтмол ажиллах хүрэлцээ боломжгүй байдгаас дотоод хяналт сулрах нөхцөл болдог.

Иймд Санхүү төрийн сангийн хэлтсийн дотоод хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлэх саналын дээд байгууллагад уламжилж өгөх. Нөгөө талаар Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2014 оны 24 дүгээр тогтоол батлагдсан төрийн сангийн үйл ажиллагааны журмаар сумын Засаг дарга, Санхүү албаны дарга төрийн сангийн өдөр тутмын гүйлгээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй байдаг. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан аймгийн нэгтгэсэн тайлангийн зөрчлөөс чөлөөлж сумдад зөвлөмж хүргүүлж зөрчлийг арилгуулах саналыг хүргүүлж хүлээн авна уу.

Асуудлын бүртгэлийн 5 дахь асуудал: Тайлант онд 22 нэр төрлийн орлогоос 16 нэр төрлийн орлогыг 5581.2 сая төгрөгөөр давуулж, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамжийн орлого, газрын төлбөрийн орлого, хог хаягдлын хураамжийн орлого, ногдол ашиг, нэр заагдаагүй бусад орлогыг 109.3 сая төгрөгөөр тасалдуулж нийт дүнгээрээ 5471.9 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогыг давуулан биелүүлсэн.

Үл хөдлөх эд хөрөнгийн татварын хувьд Төвшрүүлэх сумын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Бэрэнмайнинг", "Арган" компаниудын хөрөнгийн татварын 39.8 сая төгрөгийн өрийг барагдуулахаар арилжааны банкин дахь харилцах дансыг хааж, хөрөнгийг битүүмжилсэн, 2020 онд үйл ажиллагаа эрхлээгүйн улмаас ҮХЭХАТ төлөөгүй зэргээс шалтгаалсан байна.

Улсын тэмдэгтийн хураамжийн орлогын хувьд нь нотариатын үйлчилгээ багассан иргэний болон лавлагаа баримт цахимжсан, тамхи худалдаалах зөвшөөрөл шинээр нэмэгдэж олгогдоогүй, мөн ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А-272 тоот тушаалаар норматив тогтоосон тухай тул согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, суманд тогтоосон тул зөвшөөрлийн тоо багассан зэргээс шалтгаалан тасарсан болно.

Хог хаягдлын хураамжийн орлогын хувьд ковидтой холбоотой 2020 оны 12 сарын хогны төлбөрийг Засгийн газрын тогтоолоор чөлөөлсөн, Цэнхэр сумын Орхон багт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүдээс хогны төлбөр авна гэж тооцоолсон боловч лиценц нь цуцлагдсан, Жаргалант сум утаагүй өрхийн тоонд төлбөр ногдуулсан, Ихтамир сумын хогны орлого он дамнаж төсөвт төвлөрүүлсэн зэргээс болж төлөвлөгөө 1,2 сая төгрөгөөр тасарсан байна.

Газрын төлбөрийн 34.6 сая төгрөгөөр тасарсан нь ашигт малтмал, газрын тосны газрын кадастрийн хэлтсийн даргын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн шийдвэрээр Цэнхэр сумын Орхон багт үйл ажиллагаа явуулж байсан 10 аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцалсантай холбоотойгоор уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч компаниуд нь 2020 онд үйл ажиллагаа явуулаагүй. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн газрын төлбөрийн нэхэмжлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар мэдээллийн санд үүсгээгүйтэй холбоотой.

Хувьцааны ногдол ашгийн хувьд Ар-Ус Ундарга ХХК нь 2019-2020 онуудад ашиггүй ажилласнаас шалтгаалсан зэргийг харгалзан үзэж зөрчлөөс чөлөөлж мөнгөн дүнгүйгээр зөвлөмж болгож өгнө үү.

Бусад асуудлуудаар илэрсэн зөрчил дутагдлыг шаардлага, зөвлөмжийн дагуу арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно.



Д.ЗОЛЖАРГАЛ